



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 352

Улаанбаатар хот

“Засгийн газрын авто бааз” төрийн өмчит  
үйлдвэрийн газрын захирлыг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2024 оны А/32 дугаар тушаалаар байгуулагдсан “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дүгнэлт болон Авлигатай тэмцэх газрын 2023 оны “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай” 05/126 дугаар албан бичгийг тус тус харгалзан “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн захирлаар Ганболдын Чинзоригийг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн захирал Г.Чинзоригтой Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

